

ЭМНЭЛЭГТ
ХЭВТЭН
ЭМЧЛҮҮЛЭГЧИД



2020 I-II

158 213

2021 I-II

91 255

-42.3%



Нийт халдварт өвчнөөр өвчлөгчид



2020 I-II

6 721

2021 I-II

4 227

-37.1%



Нялхсын эндэгдлийн түвшин
(1000 амьд төрөлтөд ногдох)

2020 I-II

13

2021 I-II

11

5 хүртэлх насны хүүхдийн
эндэгдлийн түвшин
(1000 амьд төрөлтөд ногдох)

2020 I-II

16

2021 I-II

13



2/2021

Тархаасан: 2021 оны 3 дугаар сарын 11



Улсын хэмжээнд 2021 оны эхний 2 сард 11.3 мянган эх амаржсан нь өмнөх оны мөн үеэс 587 (4.9%)-гоор буурсан байна. Амаржсан эхчүүдийн 8.5 мянга (75.1%) нь 6, түүнээс дээш удаа жирэмсний хяналтад хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 427 (4.8%)-гоор буурчээ. Нийт амаржсан эхчүүдийн 30 (0.3%) нь гэртээ төрсөн нь өмнөх оны мөн үеэс 15 (33.3%)-аар мөн л буурсан байна.


Хүснэгт 1. Амаржсан эх, төрсөн хүүхэд, жил бүрийн эхний 2 сарын байдлаар

Үзүүлэлт	2018	2019	2020	2021	$\frac{2021 \text{ I-II}}{2020 \text{ I-II}}$ %
	I-II	I-II	I-II	I-II	
Амаржсан эх	11 940	11 752	11 890	11 303	95.1
6, түүнээс дээш удаа хяналтад хамрагдсан	8 731	8 739	8 917	8 490	95.2
Гэрийн төрөлт	51	47	45	30	66.7
Амьд төрсөн хүүхэд	12 017	11 825	11 975	11 395	95.2
1 цагийн дотор хөхөө амласан хүүхэд	11 632	11 445	11 560	11 001	95.2
Төрөлхийн гажигтай төрсөн	81	103	93	98	105.4
2500 граммаас доош жинтэй төрсөн	543	507	587	450	76.7
Амьгүй төрсөн хүүхэд	68	73	64	58	90.6
Амьгүй төрөлтийн түвшин (1000 нийт төрөлтөд ногдох)	6	6	5	5	-

Эх үүсвэр: ЭМЯ-ны захиргааны мэдээлэл

Улсын хэмжээнд 2021 оны 2 дугаар сард 5569 эх амаржиж, өмнөх сараас 165 (2.9%)-аар буурчээ. Амаржсан эхчүүдийн 4252 (76.4%) нь 6, түүнээс дээш удаа хяналтад хамрагдаж, өмнөх сараас 14 (0.3%)-өөр нэмэгдсэн байна. Амаржсан эхчүүдийн 22 (0.4%) нь гэртээ төрсөн бөгөөд өмнөх сараас 14 (2.8 дахин)-өөр нэмэгджээ.

Зураг 1. Амаржсан эх, төрсөн хүүхэд, сараар, 2020-2021 он




Эх үүсвэр: ЭМЯ-ны захиргааны мэдээлэл

Эрүүл мэндийн яамны “Төрөлтийн цахим бүртгэл”-ээр 2021 оны 2 дугаар сард 5378 эх амаржиж, 5447 хүүхдэд регистрийн дугаар олгожээ. Нийт төрсөн хүүхдийн 2819 нь эрэгтэй, 2628 нь эмэгтэй, 137 нь ихэр, хүүхдийн дундаж жин 3423 грамм, дундаж өндөр 50.8 см байна.


Амаржсан эхчүүдийг насны бүлгээр харвал, 3.8 хувь нь 20 хүртэлх насных, 92.6 хувь нь 20-39 насных, 3.6 хувь нь 40-өөс дээш насныхан байна.

Амаржсан эхчүүдийн 1.2 хувь нь боловсролгүй, 3.4 хувь нь бага, 12.2 хувь нь суурь, 35.3 хувь нь бүрэн дунд, 5.5 хувь нь техникийн болон тусгай мэргэжлийн, 41.0 хувь нь дипломын болон бакалаврын дээд, 1.4 хувь нь магистр, докторын зэрэгтэй байна. Амаржсан эхчүүдийн 54.6 хувь нь гэрлэлтээ албан ёсоор батлуулсан, 43.8 хувь нь гэрлэлтээ албан ёсоор батлуулаагүй, 1.6 хувь нь гэрлэлтээ цуцлуулсан байна.

Зураг 2. Амаржсан эх, насны бүлэг, дүнд эзлэх хувиар, дүнд эзлэх 2021 оны 2 дугаар сар



Зураг 3. Амаржсан эхийн боловсролын түвшин, хувиар, 2021 оны 2 дугаар сар



Эх үүсвэр: ЭМЯ-ны төрөлтийн цахим бүртгэл

Тайлбар: Энэхүү мэдээлэл нь ЭМЯ-ны захиргааны мэдээллээс тайлагнасан хугацааны хувьд өөр учир зөрүүтэй болно.

Улсын хэмжээнд 2021 оны эхний 2 сард 11.4 мянган хүүхэд төрсөн нь өмнөх оны мөн үеэс 580 (4.8%)-аар буурсан байна. Нийт амьд төрсөн хүүхдийн 11.0 мянга (96.5%) нь төрсний дараа 1 цагийн дотор хөхөө амласан бөгөөд өмнөх оны мөн үеэс 559 (4.8%)-өөр буурчээ. Нийт амьд төрөлтийн 98 (0.9%) нь төрөлхийн гажигтай, 450 (3.9%) нь 2500 граммаас бага жинтэй байна. Амьгүй төрөлтийн түвшин 1000 нийт төрөлтөд 5 ногдож байна.

Улсын хэмжээнд 2021 оны 2 дугаар сард 5624 хүүхэд амьд төрсөн нь өмнөх сараас 147 (2.5%)-гоор буурчээ. Нийт амьд төрсөн хүүхдийн 5403 (96.1%) нь төрсний дараа 1 цагийн дотор хөхөө амласан нь өмнөх сараас 195 (3.5%)-аар буурсан байна. Нийт амьд төрөлтийн 50 (0.9%) нь төрөлхийн гажигтай, 230 (4.1%) нь 2500 граммаас бага жинтэй байна. Амьгүй төрөлтийн түвшин 1000 нийт төрөлтөд 5 ногдож байна.

Улсын хэмжээнд 2021 оны эхний 2 сард нас баралтын 2388 тохиолдол бүртгэгдсэний 648 (27.1%) нь эмнэлэгт, 1740 (72.9%) нь гэрийн (бусад газарт) нас баралт байна. Нийт нас баралт өмнөх оны мөн үеэс 276 (10.4%)-гаар, гэрийн (бусад газарт) нас баралт 126 (6.8%)-гаар, эмнэлгийн нас баралт 150 (18.8%)-аар тус тус буурчээ.

Хүснэгт 2. Нас баралт, эх, хүүхдийн эндэгдэл, жил бүрийн эхний 2 сарын байдлаар

Үзүүлэлт	2018 I-II	2019 I-II	2020 I-II	2021 I-II	$\frac{2021 \text{ I-II}}{2020 \text{ I-II}}$ %
Нас баралт	2 856	2 931	2 664	2 388	89.6
Эмнэлэгт нас баралт	773	936	798	648	81.2
Гэртээ (бусад газарт)	2 083	1 995	1 866	1 740	93.2
Эхийн эндэгдэл	1	3	7	-	-
Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	221	230	193	145	75.1
Нялхсын эндэгдэл	190	192	156	126	80.8
Нярайн эндэгдэл	123	112	91	95	104.4
Эхийн эндэгдлийн харьцаа	8	25	58	-	-
Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин	18	19	16	13	-
Нялхсын эндэгдлийн түвшин	16	16	13	11	-
Нярайн эндэгдлийн түвшин	10	9	8	8	-

Эх үүсвэр: ЭМЯ-ны захиргааны мэдээлэл


Энэ оны 2 дугаар сард нас баралтын 1237 тохиолдол бүртгэгдсэний 326 (26.4%) нь эмнэлэгт, 911 (73.6%) нь гэрийн (бусад газарт) нас баралт байна. Нийт нас баралт өмнөх сараас 86 (7.5%)-гаар, гэрийн нас баралт (бусад газарт) 82 (9.9%)-оор, эмнэлгийн нас баралт 4 (1.2%)-өөр тус тус нэмэгджээ.

Улсын хэмжээнд 2021 оны эхний 2 сарын байдлаар нийт нас баралтын 6.1 хувийг 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 86.9 хувийг нялхсын эндэгдэл, нялхсын эндэгдлийн 75.4 хувийг нярайн эндэгдэл эзэлж байна. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 145 болж, өмнөх оны мөн үеэс 48 (24.9%)-аар, нялхсын эндэгдэл 126 болж, 30 (19.2%)-аар тус тус буурч, харин нярайн эндэгдэл 95 болж, 4 (4.4%)-өөр нэмэгдсэн байна.

Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 2021 оны эхний 2 сард 13 болж, өмнөх оны мөн үеэс 3-аар, нялхсын эндэгдлийн түвшин 11 болж, 2-оор буурч, нярайн эндэгдлийн түвшин 8 болж, адил түвшинд байна.

Харин энэ оны 2 дугаар сард тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 11 болж, өмнөх сараас 3-аар, нялхсын эндэгдлийн түвшин 9 болж, 4-өөр, нярайн эндэгдлийн түвшин 7 болж, 3-аар тус тус буурсан байна.

Зураг 4. Хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох), сараар, 2020-2021 он



Эх үүсвэр: ЭМЯ-ны захиргааны мэдээлэл

Халдварт өвчнөөр өвчлөгчид 2021 оны эхний 2 сард 4227 болж, өмнөх оны мөн үеэс 2494 (37.1%)-өөр буурахад салхин цэцгээр өвчлөгчид 1428 (97.1%)-аар, гар, хөл, амны өвчнөөр өвчлөгчид 130 (82.3%)-аар, цусан суулгаар өвчлөгчид 232 (77.1)-оор, вирүст хепатитаар өвчлөгчид 56 (66.7%)-гаар, мөөгөнцрөөр өвчлөгчид 406 (53.4%)-гаар, сүрьеэгээр өвчлөгчид 196 (38.6%) –гаар, трихомониазаар өвчлөгчид 447 (47.9%)-гоор, тэмбүүгээр өвчлөгчид 596 (48.9%)-гаар, гонококкт халдвар 524 (48.8%)-өөр буурсан нь нөлөөлжээ.

Хүснэгт 3. Халдварт өвчин, төрлөөр, жил бүрийн эхний 2 сарын байдлаар

Үзүүлэлт	2018 I-II	2019 I-II	2020 I-II	2021 I-II	$\frac{2021 \text{ I-II}}{2020 \text{ I-II}} \%$
Халдварт өвчнөөр өвчлөгчид	6 002	6 591	6 721	4 227	62.9
Цусаар дамжих	91	74	84	28	33.3
Вирүст хепатит	91	74	84	28	33.3
Амьсгалын замаар дамжих	2 382	2 718	2 137	383	17.9
Сүрьеэ	527	540	508	312	61.4
Салхин цэцэг	1 527	2 006	1 471	43	2.9
Гар, хөл, амны өвчин	328	172	158	28	17.7
Гэдэсний халдварт	521	518	301	69	22.9
Цусан суулга	521	518	301	69	22.9
Бэлгийн замаар дамжих	2 415	2 428	3 227	1 658	51.4
Тэмбүү	987	851	1 218	622	51.1
Гонококкт халдвар	753	899	1 074	550	51.2
Трихомониаз	673	676	933	486	52.1
ХДХВ/ДОХ	2	2	2	-	-
Бусад	293	275	761	2 047	2.7¹
Мөөгөнцөр	293	275	761	355	46.6
Коронавируст халдвар	-	-	-	1 692	-

¹ Дахин

Эх үүсвэр: ЭМЯ-ны захиргааны мэдээлэл

Халдварт өвчнөөр өвчлөгчдийг халдварын замын төрлөөр авч үзэхэд 2021 оны 2 дугаар сарын байдлаар бэлгийн замаар дамжих халдварын тохиолдол 683 болж, өмнөх сараас 292 (29.9%)-оор, цусаар дамжих халдварын тохиолдол 12 болж, 4 (25.0%)-өөр, амьсгалын замаар дамжих халдварын тохиолдол 177 болж, 29 (14.1%)-өөр, гэдэсний халдварт өвчин 27 болж, 15 (35.7%)-аар буурч, харин бусад өвчлөл 1292 болж, 537 (71.1%)-гоор нэмэгдсэн байна.


Улсын хэмжээнд 2021 оны 2 дугаар сард ХДХВ/ДОХ-ын тохиолдол илрээгүй бөгөөд нийт бүртгэгдсэн тохиолдол 311 байна.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Дэлхийн хэмжээнд 2020 оны 1 дүгээр сараас 2021 оны 2 дугаар сард коронавирусын өвчлөлийн тохиолдол 223 улсад нийт 113.4 сая бүртгэгдэж, 2.5 сая хүн нас баржээ.

Коронавирусын өвчлөлийн тохиолдол 2021 оны 2 дугаар сард дэлхийн 212 улсад 11.2 сая бүртгэгдэж, өмнөх сараас 8.7 сая (43.8%) тохиолдлоор, нас баралтын тохиолдол 305.2 мянга бүртгэгдэж, өмнөх сараас 109.4 мянга (26.4%)-аар тус тус буурчээ.


Зураг 5. Дэлхийн хүн амын коронавирусын өвчлөл, нас баралтын тохиолдол, сараар, 2020-2021 он




Эх үүсвэр: ДЭМБ-ын мэдээлэл

Коронавирусын өвчлөлийн нийт тохиолдлыг дэлхийн улс орнуудын бүс нутгаар, 2021 оны 2 дугаар сарын байдлаар харвал Америкийн бүс нутаг хамгийн их буюу 44.5 хувь, хамгийн бага нь Номхон далайн баруун бүсийн орнууд 1.4 хувь байна.

Зураг 6. Дэлхийн хүн амын коронавирусын өвчлөлийн тохиолдол, бүс нутгаар, дүнд эзлэх хувиар, 2021 оны 2 дугаар сар



Зураг 7. Дэлхийн хүн амын коронавирусын нас баралтын тохиолдол, бүс нутгаар, дүнд эзлэх хувиар, 2021 оны 2 дугаар сар




Эх үүсвэр: ДЭМБ-ын мэдээлэл

Коронавирусын нас баралтын нийт тохиолдлын 47.8 хувь нь Америкийн бүс нутгийн орнуудад, хамгийн бага нь Номхон далайн баруун бүсийн орнуудад 1.2 хувь бүртгэгджээ.


Коронавирус Монгол Улсад

Монгол Улсад 2021 оны 2 дугаар сарын байдлаар коронавирусын нийт 2907 тохиолдол бүртгэгдсэний 2249 (77.4%) нь эдгэрсэн байна. Нийт тохиолдлын 414 (14.2%) нь зөөвөрлөгдсөн, 2493 (85.8%) нь дотоодод тархсан халдвар байна.

Зураг 8. Коронавирусын тохиолдлын тоо, сараар, 2020-2021 он



Зураг 9. Коронавирусын тохиолдлын тоо, насны бүлэг, хүйсээр, 2021 оны 2 дугаар сар



Эх үүсвэр: ЭМЯ-ны захиргааны мэдээлэл

Харин энэ оны 2 дугаар сард коронавирусын 4 зөөвөрлөгдсөн, 1124 дотоодод тархсан халдвар, нийт 1128 тохиолдол илэрсэн нь өмнөх сараас 564 (2.0 дахин)-өөр нэмэгджээ. Коронавирусын нийт тохиолдлын 495 (43.9%) нь эрэгтэй, 633 (56.1%) нь эмэгтэй байна. Насны бүлгээр харвал 20-44 насныхан 533 (47.3%), 0-19 насныхан 301 (26.7%), 45-аас дээш насныхан 294 (26.1%) байна.

АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР:

Нярайн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн жилд 0-28 хоногтой эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Эхийн эндэгдлийн харьцаа (100000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд эндсэн эхийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Амьд төрөлт: Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар үргийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан, эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байсан зэргийг (хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүй) хамруулна.

Амьгүй төрөлт: Жирэмсний 22 долоо хоног ба түүнээс хойших хугацаанд, 500 граммаас дээш жинтэй төрсөн нярайд амьдын шинж тэмдгийн аль нь ч (зүрхний цохилт, судасны лугшилт, булчингийн хөдөлгөөн) илрэхгүй байгааг хэлнэ.

Эндсэн эх: Жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөлт болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндсэнийг хамруулна.

Амьгүй төрөлтийн түвшин (1000 нийт төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд нийт төрсөн хүүхдийн тоог амьгүй төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Эх үүсвэр: Эрүүл мэндийн яамны сарын мэдээ
Ангилал, код: Өвчний олон улсын ангилал /ICD-10/.

Мэдээлэл авах линкүүд:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь: 2021 оны 4 дүгээр сарын 15



*Хүн ам, нийгмийн статистикийн
газрын дарга А.Амарбал
Утас : (976-51)-264805*

*Хүн ам, нийгмийн статистикийн газрын
статистикч Г.Урангоо
Утас : (976-51)-263966*

